

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/1/НА-СТА-ОНА

ТӨВ ЧАНДМАНЬ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ГАЗАР
ОНӨААТҮГ-ЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	18
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	18
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.16 № 01/215
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 654,453.8 мянган төгрөг батлагдсанаас төлөвлөгөөт зардлын 49 хувь буюу 317,458.3 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэн, 129,774.4 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд өөрийн хөрөнгөөр 314,604.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2,704,761.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, хөрөнгийн дахин үнэлгээгээр 3,616.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тайлант онд гүйцэтгэлээр 8,969,372.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж,

9,378,252.9 мянган төгрөгийн зардал гарган, 408,880.8 мянган төгрөгийн алдагдалтай, зорилтот түвшний төлөвлөгөөт алдагдлыг 50 хувиар бууруулан ажилласан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	12,521,182.76	43,167,444.06
1.1.2	Дансны авлага	698,002,197.62	664,847,300.28
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	13,389,412.53	31,671,934.27
1.1.6	Бараа материал	407,482,579.19	306,262,101.92
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	37,700,386.68	32,358,485.52
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,169,095,758.78	1,078,307,266.05
1.2.1	Үндсэн хөрөнгө	13,504,245,895.52	14,962,517,010.41
1.2.2	Биет бус хөрөнгө	1,457,978,444.56	1,473,095,663.90
1.2.3	Биологийн хөрөнгө	4,930,000.00	5,590,000.00
1.2.9	Дуусаагүй барилга	1,123,846,914.00	1,123,846,914.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,091,001,254.08	17,565,049,588.31
1.3	Нийт хөрөнгийн дүн	17,260,097,012.86	18,643,356,854.36
2.1.1.1	Дансны өглөг	626,330,727.38	859,167,970.44
2.1.1.3	Татварын өр	290,814,668.20	348,900,531.27
2.1.1.4	НДШ - ийн өглөг	116,573,342.75	47,645,356.68
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл		30,240,000.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	11,529,987.75	3,860,708.85
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	25,529,555.04	21,850,017.40
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,070,778,281.12	1,311,664,584.64
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	20,919,804.50	8,960,969.95
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	20,919,804.50	8,960,969.95
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,091,698,085.62	1,320,625,554.59
2.3	Өмч	7,016,820,599.85	7,016,820,599.85
2.3.1	- төрийн	7,016,820,599.85	7,016,820,599.85
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,684,972,734.77	2,023,477,561.76
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	7,153,256,491.73	9,377,964,826.06
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(686,650,899.11)	(1,095,531,687.90)
2.3.11	Эздийн өмчийн дүн	16,168,398,927.24	17,322,731,299.77
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	17,260,097,012.86	18,643,356,854.36

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	7,916,831,009.04	8,847,907,404.78
2	Борлуулалтын өртөг	7,565,512,011.18	9,038,778,695.49
3	Нийт ашиг (алдагдал)	351,318,997.86	(190,871,290.71)
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	230,903,260.65	121,464,723.36
9	Борлуулалт, маркетингийн зардал	118,871,682.18	124,641,344.21
10	Ерөнхий ба удирдлагын зардал	74,947,682.73	86,002,839.36
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	251,338,604.05	128,830,037.87
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	137,064,289.55	(408,880,788.79)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	137,064,289.55	(408,880,788.79)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	137,064,289.55	(408,880,788.79)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	137,064,289.55	(408,880,788.79)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-ны үлдэгдэл	7,016,820,599.85	2,684,972,734.77	7,072,426,488.84	(823,715,188.66)	15,950,504,634.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-	-
3	Залруулсан үлдэгдэл	7,016,820,599.85	2,684,972,734.77	7,072,426,488.84	(823,715,188.66)	15,950,504,634.80
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				137,064,289.55	137,064,289.55
5	Бусад дэлгэрэнгүй орлого		-	240,971,587.00		240,971,587.00
6	Өмчид гарсан өөрчлөлт		-	(160,141,584.11)		(160,141,584.11)
7	Зарласан ногдол ашиг		-		-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	7,016,820,599.85	2,684,972,734.77	7,153,256,491.73	(686,650,899.11)	16,168,398,927.24
10	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл				-	-
11	Залруулсан үлдэгдэл	7,016,820,599.85	2,684,972,734.77	7,153,256,491.73	(686,650,899.11)	16,168,398,927.24
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(408,880,788.79)	(408,880,788.79)
13	Бусад дэлгэрэнгүй орлого		3,616,525.00	2,704,761,770.86		2,708,378,295.86
14	Өмчид гарсан өөрчлөлт			(480,053,436.53)		(480,053,436.53)
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(665,111,698.01)			(665,111,698.01)
17	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	7,016,820,599.85	2,023,477,561.76	9,377,964,826.06	(1,095,531,687.90)	17,322,731,299.77

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	8,923,106,155.48	9,446,689,911.82
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,090,316,700.13	9,203,566,151.82
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	8,917,294.00	-
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	569,845,825.44	243,123,760.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	254,026,335.91	-
1.2	Мөнгөн зарлагын дүн	8,653,847,459.01	9,075,965,356.83
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,967,291,460.00	2,173,930,045.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	605,200,443.50	803,284,036.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	982,249,592.01	1,132,923,269.25
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	740,412,544.23	758,292,952.80
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,575,206,922.67	3,552,280,935.92
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	531,030,019.55	550,488,582.13
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,117,873.00	1,270,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	251,338,604.05	103,495,535.73
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	269,258,696.47	370,724,554.99
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	7,184,240.00	26,100,082.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	7,184,240.00	26,100,082.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн	291,207,226.71	366,178,375.69
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	284,147,226.71	333,995,535.69
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	7,060,000.00	32,182,840.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(284,022,986.71)	(340,078,293.69)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(14,764,290.24)	30,646,261.30
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	27,285,473.00	12,521,182.76
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	12,521,182.76	43,167,444.06

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
	Борлуулсан дулаан	мян.төг	5,768,986.8	6,679,840.8	6,726,213.3	46,372.5	100.7
	Борлуулсан цэвэр ус	мян.төг	685,124.5	862,039.0	870,625.5	8,586.5	101.0
	Татан зайлуулсан бохир ус	мян.төг	355,597.8	368,773.9	380,288.1	11,514.2	103.1
	Орон сууцны засварын орлого	мян.төг	7,895.6	7,895.6	9,984.8	2,089.2	126.5
	Бохир гэсгээлтийн орлого	мян.төг	2,594.4	2,594.4	4,659.9	2,065.5	179.6
	Бусад борлуулалт /зөөврийн бохир/	мян.төг	112,386.5	30,070.6	64,067.8	33,997.2	213.1
	ХО-ын өгөөжийн орлого	мян.төг	111,761.5	315,261.5	480,053.4	164,791.9	152.3
	Гэрээт ажлын орлого	мян.төг	41,820.4	-	40,233.9	40,233.9	-
	Бусад орлого	мян.төг	161,244.9	15,899.7	55,522.4	39,622.7	349.2
	СӨХ-ны орлого	мян.төг	117,434.2	113,751.7	113,438.5	(313.2)	99.7
	Санхүүжилт	мян.төг	569,845.8	168,978.6	224,284.5	55,305.9	132.7
2	Нийт орлого	мян.төг	7,934,692.4	8,565,105.8	8,969,372.1	404,266.3	104.7
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	7,916,831.0	8,549,206.1	8,913,849.7	364,643.6	104.3
3	Нийт зардал	мян.төг	7,797,627.9	9,387,896.3	9,378,252.9	(9,643.4)	99.9
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	7,565,512.1	9,147,886.9	9,118,227.4	(29,659.5)	99.7
	Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	193,819.4	225,416.3	210,644.1	(14,772.2)	93.4
	Удирдлагын зардал	мян.төг	74,947.7	89,157.4	86,002.8	(3,154.6)	96.5
	Борлуулалтын зардал	мян.төг	118,871.7	136,258.9	124,641.3	(11,617.6)	91.5
	Бусад зардал	мян.төг	38,296.4	14,593.1	49,381.4	34,788.3	338.4
4	Цэвэр ашиг, алдагдал	мян.төг	137,064.5	(822,790.5)	(408,880.8)	413,909.7	49.7

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ нь эрхэм зорилгоо “Зуунмод хотын хүн ам, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг стандартын ундны болон ахуйн хэрэглээний цэвэр ус болон дулааны эрчим хүчээр хангаж, орон сууц, сувагжуулалтын ашиглалт, үйлчилгээг сайжруулж, инженерийн байгууламж, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, хэрэглэгчдийнхээ эрх ашгийг дээдлэн ажиллана” гэж тодорхойлсон.

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хотын хүн ам, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг ундны болон ахуйн хэрэглээний стандартын цэвэр усаар хангах үйлчилгээ
- Хотын орон сууц, аж ахуйн нэгж байгууллагуудын сувагжуулалтын болон орон сууцны үйлчилгээ
- Хотын орон сууц, аж ахуйн нэгж байгууллагуудыг дулааны эрчим хүчээр хангах үйлчилгээ. Дулаан үйлдвэрлэл;
- Хотын инженерийн бүх төрлийн байгууламж, шугам сүлжээ, сантехникийн ашиглалт, засвар үйлчилгээ
- Компани нь үндсэн үйлдвэрлэл, үйл ажиллагааг дэмжсэн туслах үйлдвэрлэл

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Төв аймгийн ИТХ байх бөгөөд компанийн өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгах шийдвэр гаргаж гүйцэтгэлд нь хяналт тавьдаг байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 63 дугаар “Аж ахуйн нэгжийг өөрчлөн байгуулах тухай” тогтоолын дагуу байгуулагдаж, хавсралтаар байгууллагын дүрмийг баталсан байна.

Байгууллагын дүрмийн 4.1.1-д заасан аймгийн ИТХ-ын бүрэн эрхийг “Компанийг өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих”, 4.2.1-д “Компанийн гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх” гэж тус тус заасан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ”, Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ”, 16.2-т “Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана” гэсэн заалттай нийцэж байна.

Байгууллагын удирдлага болон ТУЗ-ын бүрэлдэхүүнийг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 12 дугаар тогтоолоор шинэчлэн байгуулж, ТУЗ-ын зөвлөл нь төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч хараат 7 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь цалин, урамшуулал авахгүйгээр ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал

тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоол “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тогтоол “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,383,259.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,521.2	43,167.4	30,646.2
Авлага	711,391.6	696,519.2	(14,872.4)
Бараа материал	407,482.6	306,262.1	(101,220.5)
Урьдчилж төлсөн зардал тооцоо	37,700.4	32,358.5	(5,341.9)
Үндсэн хөрөнгө	13,504,245.9	14,962,517.0	1,458,271.1
Биет хөрөнгө	1,457,978.4	1,473,095.7	15,117.3
Биологийн хөрөнгө	4,930.0	5,590.0	660.0
Дуусаагүй барилга	1,123,846.9	1,123,846.9	-

Нийт хөрөнгө	17,260,097.0	18,643,356.8	1,383,259.8
Богино хугацаат өр төлбөр	1,070,778.3	1,311,664.5	240,886.2
Урт хугацаат өр төлбөр	20,919.8	8,961.0	(11,958.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,016,820.6	7,016,820.6	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,684,972.7	2,023,477.6	(661,495.1)
Эздийн өмчийн бусад хэсэг	7,153,256.5	9,377,964.8	2,224,708.3
Хуримтлагдсан ашиг/алдагдал	(686,650.9)	(1,095,531.7)	(408,880.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	17,260,097.0	18,643,356.8	1,383,259.8

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөрийн данснуудад байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 43,167.4 мянган төгрөг буюу 30,646.2 мянган төгрөгөөс өссөн байна. Тайлант оны эцэст касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлгүй, харилцах дансны 43,167.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 14,872.4 мянган төгрөгөөр буурч, 696,519.2 мянган төгрөг байгаагаас 664,847.3 мянган төгрөгийн дансны авлага, 31,671.9 мянган төгрөгийн татварын авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 306,262.1 мянган төгрөг болж өмнөх оноос 101,220.5 мянган төгрөгөөр буурсан нь нүүрсний нөөц өмнөх оноос буурснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,458,271.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 314,604.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2,704,761.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, хөрөнгийн дахин үнэлгээгээр 3,616.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Тайлант онд өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 12,055.1 мянган төгрөгийн хөрөнгийг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүсэлт хүргүүлэн дахин үнэлж данс бүртгэлд тусган тайлагнасан байна.

Дуусаагүй барилга данс 1,123,846.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь 2001 онд Дулааны станц ашиглалтад өгөхөөр туршилт хийгдсэн боловч Улсын комисс хүлээж аваагүй тул одоог хүртэл ашиглаагүй байна. Аймгийн орон нутгийн өмчийн газраас зохих тоног төхөөрөмжүүдийг худалдах арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,311,664.5 мянган төгрөг болж 240,886.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Тайлант оны эцэст бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх өглөг 859,167.9 мянган төгрөг, татварын өглөг 348,900.5 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 47,645.4 мянган төгрөг, богино хугацаат зээл 30,240.0 мянган төгрөг, урьдчилж олсон орлого 3,860.0 мянган төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 21,850.0 мянган төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 8,961.0 мянган төгрөг болж өмнөх оноос 11,958.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмнөх үеийн хуримтлагдсан алдагдал 1,095,531.7 мянган төгрөг болж 408,880.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл,

санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Захирлын 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 237 дугаар тушаалаар 2022 оны бизнес төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг томилогдон ажиллаж, 2022 оны бизнес төлөвлөгөөний төсвийн төслийг боловсруулан, ТУЗ-ын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Үүнээс:

- Үндсэн үйл ажиллагааны орлого 8,565,105.8 мянган төгрөг
- Үйл ажиллагааны зардал 9,387,896.3 мянган төгрөг
- Алдагдал 822,790.5 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын ТУЗ-ын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг Дулаан эрчим хүчний орлогын дүнг 233,000.0 мянган төгрөгөөр бууруулж, шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалж нүүрс тээврийн үнэ өссөн, галч нарын цалин бага байгаагаас ажиллах хүчний хомсдол үүссэний улмаас галч нарын цалинг 500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, үйл ажиллагааны зардлыг 540,000.0 мянган төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 8,969,372.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 9,378,252.9 мянган төгрөгийн зардал гарган, 408,880.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 8,696,372.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 404,266.3 мянган төгрөгөөр давсан нь Монгол Улсын Засгийн газраас Коронвируст цар тахал үүссэнтэй холбоотойгоор Төв аймгийн 23 сумын гэр хорооллын усан хангамжийн санхүүжилт 79,578.6 мянган төгрөг, төлөвлөгөөнд тусгагдаагүй гэрээт ажлын орлого 40,233.9 мянган төгрөг, үндсэн үйлдвэрлэлийн борлуулалтын орлого 72,249.8 мянган төгрөг, Бүрэн сумын халаалтын зуухны орлого 32,375.5 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын өгөөжийн орлого 164,792.0 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 39,622.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 9,378,252.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 9,643.2 мянган төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны зардал төлөвлөснөөс 160,935.1 мянган төгрөг хэмнэж ажилласан боловч үнийн өсөлтэй холбоотойгоор төлөвлөгөөнд тусгагдаагүй зайлшгүй зардал гарч, гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 654,453.8 мянган төгрөг батлагдсанаас тайлант онд төлөвлөгөөт зардлын 49 хувь буюу 317,458.3 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэн, 129,774.4 мянган төгрөгийн хэмнэсэн байна. Энэ нь зарим зардлыг дотоод нөөц бололцоог ашиглан хэмнэн ажиллаж, халаалтын 2 болон 3 дугаар зуухнуудад Аймгийн хөрөнгө оруулалтаар шинэчлэл хийснээс шалтгаалсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж, худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байх холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор Н.Тэмүүжин, С.Батжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангаа “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан зорилтот түвшний нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны зорилтот түвшний гүйцэтгэлийн тайланг, суурь үзүүлэлтийг батлагдсан зорилтот түвшний нийт зардал 8,847,896.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 132,718.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 99,538.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр удирдлагын зардал 3,154.6 мянган төгрөг, борлуулалтын зардал 11,617.6 мянган төгрөг, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 29,659.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, төлөвлөгөөт алдагдлыг 413,909.7 мянган төгрөгөөр буюу 50 хувиар бууруулан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 146 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 144 мэдээллийг хугацаандаа, 2 мэдээллийг хугацаа хоцроосон нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээлэх мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь 2022 оны "Худалдан авах ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө"-өөр нийт 5,287,127.4 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөснөөс нээлттэй тендер шалгаруулалтаар 4,280,565.9 мянган төгрөг, шууд худалдан авалтаар 1,006,561.5 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөсөн байна. Нээлттэй тендер шалгаруулалтаар нийт 5 худалдан авалт төлөвлөснөөс тайлант онд 4 худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан ажилласан байна. Үүнд :

- Нүүрс түүнийг бэлтгэн нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулалт 3,004,659.2 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,028,946.9 мянган төгрөг,
- Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авах нийлүүлэгчийг сонгон шалгаруулалт 156,782.2 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 155,023.9 мянган төгрөг,
- Шатахуун, шатах тослох материал нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулалт 174,449.4 мянган төгрөг төлөвлөснөөс 136,491.0 мянган төгрөг,
- Өвөлжилтийн бэлтгэл ажил хангахад шаардагдах материал худалдан авах нийлүүлэгчийг сонгон шалгаруулалт 856,675.1 мянган төгрөг төлөвлөснөөс 649,442.8 мянган төгрөгийн гэрээг байгуулан ажилласан байна.

Тайлант онд нийт 5,287,127.4 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 4,844,109.5 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээ байгуулан ажилласан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 62,994.1 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс 21,613.9 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 41,380.3 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Б	1	2	3	4	5	6
1	Акт	-	-	-	-	-
2	Албан шаардлага	4	21,613.9	4	21,613.9	100.0
3	Зөвлөмж	5	41,380.3	5	41,380.3	100.0
	Нийт дүн	9	62,994.1	9	62,994.1	100.0

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,250.5 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс, 5,452.0 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 17,798.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 5,452.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоов.

1. Тайлант онд байгууллагын хөрөнгөөр 4,018.0 мянган төгрөгийн хүүхдийн баярын бэлэг бэлтгэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг, дурсгалын зүйл худалдан авах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн байгууллагын хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан зардлыг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд салбарын тэргүүний цол тэмдгээр шагнагдсан 11 албан хаагчдад 790.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал давхардуулан олгосон нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 1.7-д "Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагналд мөнгө дагалдахгүй" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн давхардуулан олгосон шагналыг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Тайлант оны 12 дугаар сард захирлын тушаал шийдвэрээр томилогдоогүй 1 хүнд 643.4 мянган төгрөгийн цалин тооцож олгосон нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон цалинг буруутай этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Тайлант оны төлөвлөгөөгөөр 292 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 296 орон тоогоор ажиллаж, 4 орон тоо хэтрүүлсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 3 байгууллагын 17,798.5 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх" заавартай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
1	Байхгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Тайлант онд байгууллагын хөрөнгөөр 4,018.0 мянган төгрөгийн бэлэг бэлтгэж, тараасан	1	4,018.0	1	4,018.0								
2	Тайлант онд Салбарын тэргүүний цол тэмдгээр шагнагдсан 11 албан хаагчдад 790.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал давхардуулан олгосон	1	790.0	1	790.0								
3	Тайлант оны 12 дугаар сард захирлын тушаал шийдвэрээр томилогдоогүй 1 хүнд 643.4 мянган төгрөгийн цалин тооцож олгосон	1	643.4	1	643.4								
4	Тайлант оны төлөвлөгөөгөөр 292 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 296 орон тоогоор ажиллаж, 4 орон тоо хэтрүүлсэн	1	-			1	-						
5	Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 3 байгууллагын 17,798.5 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй	1	17,798.5					1	17,798.5				
	Дүн	5	23,250.5	3	5,452.0	1	-	1	17,798.5				

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1	Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 144 мэдээллийг хугацаандаа, 2 мэдээллийг хугацаа хоцроосон	1	-						
	Нийт дүн	1	-						

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn